

МОНГОЛ УЛСЫН
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны ... дугаар
сарын ... -ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Соёлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам”-ыг бүх хэлбэрийн соёлын байгууллага мөрдсүгэй.

3. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Соёл, урлагийн газар (Б.Мөнхзул)-д, Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.

4. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ж.Отгонбат)-д үүрэг болгосугай.

САЙД

Ч.НОМИН

Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Соёлын тухай хуулийг хэрэгжүүлэх, соёлын үнэт зүйлийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог бий болгох, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх, ашиглахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2. Журмын зорилго нь Монгол Улсын Соёлын үнэт зүйлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр уг санд бүртгэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.3. Соёлын үнэт зүйлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг сум, аймаг, нийслэлийн соёл урлагийн газруудын Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, соёлын үнэт зүйлийн улсын нэгдсэн Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (цаашид “Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” гэх)-г бүрдүүлэх, хөтлөх, ашиглахад энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Соёлын үнэт зүйлийн Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо

- 2.1. Соёлын үнэт зүйлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан соёлын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төрөлжсөн дараах мэдээллийн сангаас бүрдэнэ.
 - 2.1.1. соёлын өвийг хамгаалах;
 - 2.1.2. музейн;
 - 2.1.3. номын сангийн;
 - 2.1.4. ном, утга зохиолын бүтээл туурвих, түгээх;
 - 2.1.5. хөгжмийн урлагийн бүтээл туурвих, үйлдвэрлэх, түгээх;
 - 2.1.6. тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх;
 - 2.1.7. дүрслэх урлаг, уран сайхны гэрэл зураг, гар урлал, хэрэглээний урлагийн бүтээл туурвих, түгээх;
 - 2.1.8. кино урлаг, дуу-дүрсний уран бүтээл туурвих, түгээх;
 - 2.1.9. интернэт орчин, тоон технологид суурилсан соёлын агуулга, харилцаа бүхий цахим уран бүтээл туурвих, түгээх;
 - 2.1.10. дизайн, архитектурын бүтээл туурвих;
 - 2.1.11. соёл, урлагийн арга хэмжээ, тоглолт, наадам зохион байгуулах;
 - 2.1.12. соёлын боловсрол олгох;
 - 2.1.13. соёл судлалын;
 - 2.1.14. соёлын ажилтны.

2.2. Соёлын үнэт зүйлийн Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах тогтолцоотой байна.

2.2.1. соёлын үнэт зүйлийг хадгалж байгаа байгууллага, иргэний;

2.2.2. сум, аймаг, нийслэлийн;

2.2.3. улсын.

2.3. Байгууллагын Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь сум, аймаг, нийслэлийн Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд, сумын Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь аймгийн Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд, аймаг, нийслэлийн Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь улсын нэгдсэн Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тус тус бүртгэл, мэдээлэл, тайланг тогтмол хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

2.4. Соёлын үнэт зүйлийн бүртгэлийг маягтыг Соёлын сайдын тушаалаар батална.

2.5. Энэхүү журамд заасан Соёлын үнэт зүйлийн Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн мэдээллийн “Цахим соёл” арга хэмжээний нэг соёл платформоор дамжуулан нийтийн хүртээл болгоно.

Гурав. Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэл

3.1. Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хуульд заасан үнэт зүйлийн чиглэл, өгөгдөл, дуу авиа, дүрс бичлэг, график, бичгийн хэлбэртэй байна.

3.2. Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

3.3. Шат, шатны Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд цуглагдаж байгаа соёлын үнэт зүйлийн бүртгэлийн бүрдлийг холбогдох албан тушаалтан шаардлага хангасан эсэхийг хянан үзэж бүртгэнэ.

3.4. Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн зорилгыг хэрэгжүүлэхэд тухайн бүртгэж байгаа байгууллага, иргэн сангийн бүрдлийг бүрэн бүрдүүлсэн байна.

3.5. Энэхүү журмын 2.4-т заасан маягтын дагуу компьютерын программ хангамжийг ашиглан үнэн зөв бүртгэн, бүрдүүлнэ.

3.6. Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн сан олон нийтэд нээлттэй байна.

Дөрөв. Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа

4.1. Төрийн өмчлөлд байгаа соёлын үнэт зүйлийг Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд заавал бүртгэнэ.

4.2. Хувийн өмчлөлд байгаа соёлын үнэт зүйлийг өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн журмын 2.4-т заасан маягтын дагуу бүрдүүлэн Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

4.3. Аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар болон соёл урлагтай холбоотой мэдээлэл бүрдүүлдэг иргэн, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн удирдлагын байгууллага энэхүү журмын 2.1-т заасан мэдээллийг бүрдүүлэх шинэчлэх бүрд мэдээллийг бүрдүүлж улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

4.4. Байгууллага, иргэдийн бүртгүүлсэн соёлын үнэт зүйлийн бүртгэлийн нууцыг чандлан хадгалах ба иргэн, байгууллагын зохиогчийн эрхийг холбогдох хууль, журмын дагуу хамгаална.

4.5. Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд соёлын үнэт зүйлийн бүртгэл, гадаад, дотоодод зохион байгуулсан үзэсгэлэн, арга хэмжээ, тайлан, цомог, соёлын үнэт зүйлийг сурталчилсан байдал, хэрэглээ болон сэргээн засварлалт зэрэг соёлын үнэт зүйлийн ашиглалт, хадгалалт, хамгаалалттай холбоотой бүхий л баримт бичгийг хадгалж бүртгэнэ.

4.7. Соёлын үнэт зүйлийн Бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага удирдан зохион байгуулна.

4.8. Улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан ажиллах бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.8.1. Мэдээллийн сангийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

4.8.2. Мэдээллийн санг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, шинэчлэх, ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.8.3. мэдээллийн сангийн хүрээнд программ хангамж, техник технологи, хүний нөөцийн нэгдмэл бодлого хэрэгжүүлэх, тэдгээрийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх;

4.8.4. хэрэглэгчийг мэдээллийн сангаас мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах;

4.8.5. нийтийн хэрэгцээний болон хоёрдогч мэдээллийг бий болгоход шаардлагатай мэдээлэл боловсруулах;

4.8.6. мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлд бүртгэл хөтлөх, баримтжуулах;

4.8.7. мэдээллийн сангийн мэдээллийг энэ журмын 4.3 дугаар зүйлд зааснаас бусад иргэн, хуулийн этгээдээс цуглуулах, сонгох, нягтлан шалгах ажлыг зохион байгуулах;

4.8.8. мэдээллийн үнэн зөв, мэдээллийн сангийн шуурхай байдал, хэвийн ажиллагаа, хамгаалалт, хадгалалт, нууцлалт, хуулбарлалтыг хариуцах;

4.8.9. мэдээллийн сангийн нөөц хувь бүрдүүлэх;

4.8.10. мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах;

4.8.11. мэдээллийн сан бүрдүүлэх асуудлаар мэдээлэл бүрдүүлэх, төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

4.8.12. мэдээллийн санд өөрчлөлт хийх, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сангийн талаарх тайланг жил бүр гаргах;

4.8.13. мэдээллийн санд халдлага, гэмтэл гарсан даруйд холбогдох байгууллагад мэдэгдэх, түүний хэвийн үйл ажиллагааг сэргээх;

4.8.14. мэдээллийн сангийн асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

4.8.15. мэдээллийн санг зориулалтын байр, программ хангамж, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, шаардлагатай өгөгдөл, мэдээлэл худалдан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгуулах.

4.9. Сум, аймаг, нийслэлийн Бүртгэл, мэдээллийн сан нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.9.1. Соёлын үнэт зүйлийг Бүртгэл, мэдээллийн санд бүртгэх ажлыг сум, аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар зохион байгуулна.

4.9.2. Сумын Бүртгэл, мэдээллийн сан нь орон нутгийнхаа нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийг бүртгэж, Бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлнэ.

4.9.3. Сум, аймаг, нийслэлийн Бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, соёлын үнэт зүйлийг бүртгэхдээ энэ журмын 3 дугаар зүйл, 4.5 дахь заалтыг мөрдлөг болгоно.

4.9.4. Тухайн сумын нутаг дэвсгэрт соёлын үнэт зүйлийн талаар байгууллага, иргэдээс ирүүлсэн ажлын тайланг хүлээн авч, Бүртгэл, мэдээллийн санд хадгална.

4.9.5. Сумын Бүртгэл, мэдээллийн сан нь бүртгэл, мэдээ тайланг аймгийн Бүртгэл, мэдээллийн санд жил бүрийн 11 сарын 1-ны дотор тогтмол хүргүүлж байна.

4.9.6. Аймгийн Бүртгэл, мэдээллийн сан нь аймгийнхаа нутаг дэвсгэр дэх соёлын үнэт зүйлийн Бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэн ажиллана.

4.9.7. Аймгийн Бүртгэл, мэдээллийн сан нь сумын Бүртгэл, мэдээллийн сангаас бүртгэл, мэдээ, тайланг тогтмол авч байна.

4.9.8. Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар тухайн орон нутаг дахь Бүртгэл, мэдээллийн сангийн бүрдэлт, баяжуулалтад хяналт тавьж, тайлан, мэдээллийг улсын Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд жил бүрийн 12 сарын 1-ны дотор тогтмол хүргүүлнэ.

4.10. Улсын Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.10.1. Улсын Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь соёлын үнэт зүйлийн бүртгэлийн программыг нэвтрүүлэн, соёлын үнэт зүйлийн улсын нэгдсэн сүлжээ, мэдээллийн санг бий болгоно.

4.10.2. Улсын Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь энэ журмын хавсралтад заасан байгууллага, аймаг, нийслэлийн Бүртгэл, мэдээллийн сангаас соёлын үнэт зүйлийн бүртгэл мэдээллийг маягтын дагуу хүлээн авч, улсын нэгдсэн санг бүрдүүлэн ажиллана.

4.10.3. Энэ журмын 4.5 дахь заалтыг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллана.

4.10.4. Улсын хэмжээнд зохион байгуулсан соёлын үнэт зүйлийн бүртгэл, тайлан мэдээг улсын Бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хадгална.

4.10.5. Соёлын үнэт зүйлийг хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, иргэдэд соёлын үнэт зүйлийг хадгалж хамгаалах, Бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх арга зүйгээр хангана.

4.10.6. Улсын Бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь улсын хэмжээнд соёлын үнэт зүйлийг сурвалжлан олох, хайгуул, судалгаа хийх, мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулна.

Тав. Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагын бүрэн эрх

5.1. Энэ журмын 4.3 дугаар зүйлд заасны дагуу улсын мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. холбогдох мэдээллийг бүрдүүлж, улсын мэдээллийн санд цахим хэлбэрээр буюу сүлжээгээр нийлүүлэх, техникийн хувьд боломжгүй бол мэдээлэл зөөгч хэрэгслээр өгөх;

5.1.2. соёлын үнэт зүйлийн өгөгдөл, мэдээллийг шинэчлэх, өөрчлөлт оруулах, шинэ өгөгдөл, мэдээллээр мэдээллийн санг баяжуулах;

5.1.3. соёлын үнэт зүйлийн өгөгдөл, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцах;

5.1.4. соёлын үнэт зүйлийн өгөгдөл, мэдээллийн анхдагч боловсруулалтыг хариуцах;

5.1.5. соёлын үнэт зүйлийн өгөгдөл, мэдээллийн нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлтийн тухай соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ажлын 14 өдөрт багтаан мэдэгдэх;

5.1.6. улсын мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх техник, технологийн нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох зардлыг хариуцах.

Зургаа. Мэдээллийн сангийн хэрэглэгчийн эрх, үүрэг

6.1. Мэдээллийн сангийн хэрэглэгч дараах эрх, үүрэгтэй:

6.1.1. мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг ашиглан эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, лавлагааны мэдээлэл бэлтгэх болон бусад хэлбэрээр ашиглахдаа мэдээлэл эзэмшигчийн нэрийг ишлэл болгох;

6.1.2. мэдээллийн сангийн үйл ажиллагаа болон өгөгдөл, мэдээллийн талаар гомдол гаргах.

Долоо. Мэдээллийн санг бүрдүүлэх ерөнхий шаардлага

7.1. Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, түгээх үйл ажиллагаа, техник, технологи нь цахим хөгжил, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн төрийн нэгдсэн бодлоготой уялдсан байна.

7.2. Мэдээллийн сангийн агуулга, нэр төрөл, хамрах хүрээ нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдоно.

7.3. Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагын техник, технологийн шийдэл нь мэдээллийн нэгдмэл байдлыг хангахад чиглэгдэнэ.

Найм. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл

8.1. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

8.1.1. мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг өөрчлөх, устгах, хулгайлах;

8.1.2. мэдээллийн сангийн программ хангамжийг өөрчлөх, устгах, эвдэх;

8.1.3. мэдээллийн сангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээний найдвартай үйл

ажиллагааг санаатай болон санамсаргүйгээр алдагдуулах, эвдэх, гэмтээх;

8.1.4. мэдээллийн санд вирус тараах;

8.1.5. мэдээллийн санд агуулагдаж буй иргэн, хуулийн этгээдийн нууцтай холбоотой мэдээллийг задруулах;

8.1.6. мэдээллийн сангаас авсан мэдээллийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор ашиглах, бусдад дамжуулах, худалдах;

8.1.7. мэдээллийн сангаас санаатай болон болгоомжгүйгээр мэдээлэл хуулбарлах, ишлэлгүйгээр ашиглах;

8.1.8. ашиглах хүрээг нь хязгаарласан өгөгдөл, мэдээлэлд хууль бусаар нэвтрэх, тэдгээрийг өөрчлөх, хуулбарлах, устгах;

8.1.9. мэдээллийн санд хандах эрхийг хууль бусаар олж авах, бусдад дамжуулах;

8.1.10. мэдээллийн сангийн ажилтан хуулиар хүлээсэн давуу эрхтэй холбоотойгоор өгөгдөл, мэдээлэл болон мэдээллийн сангийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг алдагдуулах.

Ес. Мэдээллийн сангийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл

9.1. Мэдээллийн сан төрийн өмч байх бөгөөд түүний үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

9.2. Мэдээллийн сангийн мэдээлэл нь төлбөртэй болон төлбөргүй байна. Төлбөргүй болон нийтэд зориулсан мэдээллийн жагсаалтыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.3. Иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр цуглуулж бүрдүүлсэн өгөгдөл, мэдээллийн тухай мэдээллийг улсын санд төлбөргүй өгөх үүрэгтэй.

9.4. Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь улсын төсөв, шинжлэх ухаан, технологийн сан, соёл, урлагийг дэмжих сан, кино урлагийг дэмжих сан, олон улсын болон гадаадын зээл, тусламжийн хүрээнд бүрдүүлсэн соёлын өгөгдөл, мэдээллийг улсын мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.

9.5. Мэдээллийн сангийн сургалт, танин мэдэхүй, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахтай холбоотой нийтэд зориулсан мэдээллийг иргэн, хуулийн этгээд төлбөргүй ашиглах эрхтэй.

9.6. Энэ зүйлд заасан төлбөртэй мэдээллийн орлогын 50 хүртэл хувийг мэдээллийн санг шинэчлэх, үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх, түүний хүчин чадлыг сайжруулахад зарцуулна.